



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 4/89

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7 дугаартай тогтоолоор баталсан "Гучин сая мод" хөтөлбөрийн 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Өрх бүр ногоон төгөл бүтээе" уриан дор зохион байгуулагдах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх – Засаг даргын орлогч

Нарийн бичиг: Б.Мөнх-Очир – Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Гишүүд: Г.Гантуяа – Ойн ангийн дарга

Б.Болд- Байгаль хамгаалагч

Г.Бат-Эгшиглэн- Иргэний танхимын ажилтан

2. Сумын хэмжээнд мод тарих үндэсний хөдөлгөөний хөтөлбөр, төлөвлөгөөг гарган, иргэд олон нийтийг уриалан зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501175